



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн сэдээн
Утас: 26-70-16, факс: 32-70-16
E-mail: stategra@parlament.mn
<http://www.parlament.mn>

2025. 02. 10 № 09

Г Улсын Их Хурлын тогтоолын
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 93 дугаар тогтоолоор Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 93 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан дараах асуултгыг Танд тавьж байна. Үүнд:

1.Иргэдийн орон нутагт шилжиж, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцжуулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, дэд бүтцийн бэлэн байдал, иргэд, зорилтот бүлгийн шаардлагатай уялдуулан зохион байгуулах талаар 2024 онд засгийн газраас авч хэрэгжүүлсэн ажлын тухай мэдээлэл болон тус онд орон нутаг руу шилжин суурьшсан иргэдийн статистик мэдээлэл ирүүлэх;

2.Хөдөөд орон сууцны нийлуулэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлсэн ажлын тухай мэдээлэл буюу иргэд 2024 онд орон нутагт ипотекийн зээлээр хэчнээн иргэн орон сууц авсан болон орон нутагт олгогдсон орон сууцны зээлийн санхүүжилтийн дүнг аймаг тус бүрээр гарган ирүүлэх;

3.Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны нийлуулэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт хугацааны ногоон санхүүжилтийн арга хэрэгслийг нэвтрүүлэх талаар авч хэрэгжүүлсэн ажлын тухай мэдээлэл ирүүлэх;

4.Иргэдийг орон сууцжуулах арга хэмжээг амькилттай хэрэгжүүлж байгаа орон нутгийг санхүүгийн дэмжлэгээр урамшуулах механизм бүрдүүлж, сайн туршлагыг сурталчлах ажлыг зохион байгуулах талаар хийсэн ажлын тухай мэдээлэл ирүүлэх;

5. Орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах талаар хийсэн ажлын тухай мэдээлэл буюу нийслэлд болон орон нутагт олгогдсон зээлийн санхүүжилтийн нийт дунг аймгууд болон нийслэлийн дүүргүүдээр гаргасан тайланг ирүүлэх;

6. Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м²-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцны ипотекийн зээлд хамруулах талаар хийсэн ажлын тухай мэдээлэл буюу амины орон сууцанд олгосон ипотекийн зээлийн тухай статистик мэдээлэл ирүүлэх.

Эдгээр асуултын хариут Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан албан бичгээр хариу ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Г.ЛУВСАНЖАМЦ

2025000016